



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Завханмандал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2022/122/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улиастай сум 2022 он</p>	<p>Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор Б.Дагвасүрэн Утас:99014227 Цахим хаяг: dagvasurenb@audit.gov.mn</p> <p>Аудитор Ц.Оюунсүвд Утас: 99076038 Цахим хаяг: oyunsuvdts@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
4. Аудитын илрүүлэлт.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

᠔᠔᠒᠒.᠐᠗.᠒5 № 13᠐᠗/376

танай _____ -ны № _____ -т

ЗАВХАНМАНДАЛ СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ЭРХЛЭГЧ А.ДУЛМАА-д

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Завханмандал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөний улмаас Завханмандал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

37.1 сая төгрөгийн үнэ төлбөргүй шилжиж ирсэн эм, хамгаалах хэрэгслийн, 63.7 сая төгрөгийн худалдаж авсан эм, хамгаалах хэрэгслийн зарцуулалтын баримтыг нэгтгэж боловсруулаагүй, зарцуулалтын бодит байдлыг шалгахад хангалттай нотлох баримт олж аваагүй, 4.5 сая төгрөгийн зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан, 43.5 сая төгрөгийн худалдан авалтын и-баримтыг бүрдүүлээгүй, ковидын зардлаас 1.3 сая төгрөгөөр ажилчдад биеийн тамирын хувцас бэлтгэсэн зэрэг зөрчлүүд нь (Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.3, 47 дугаар зүйлийн 47.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх зэрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй) байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>56153148.07</u>	<u>78231032.51</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	262600.00
312	Банканд байгаа бэлэн мөнгө	0.00	262600.00
3121	Төгрөг	0.00	262600.00
31211	Төрийн сангийн харилцах	0.00	262520.00
33	АВЛАГА	354919.96	18246500.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	354919.96	0.00
335	Бусад авлага	0.00	18246500.00
3351	Байгууллагаас авах авлага	0.00	18246500.00
35	БАРАА МАТЕРИАЛ	55798228.11	59721932.51
351	Түүхий эд материал	7394135.10	6318283.00
35110	Тусгай зориулалттай материал	198000.00	3962000.00
35130	Эм боох материал	7196135.10	2356283.00
354	Хангамжийн материал	43007093.01	48027649.51
35410	Бичиг хэргийн материал	1808460.00	1574860.00
35420	Аж ахуйн материал	977100.01	934800.51
35430	Сэлбэг хэрэгсэл	410000.00	0.00
35440	Түлш, шатах тослох материал	1638750.00	0.00
35450	Барилгын засварын материал	98000.00	0.00
35460	Хүнсний материал	2892764.00	5885336.00
35470	Бусад хангамжийн материал	35182019.00	39632653.00
35600	Мал амьтад	5397000.00	5376000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>510692986.94</u>	<u>514355076.40</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	510692986.94	514355076.40
392	Биет хөрөнгө	503272986.94	506935076.40
39201	Барилга, байгууламж, орон сууц	470251210.00	470251210.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-38677327.56	-69883734.84
39203	Авто-тээврийн хэрэгсэл	42791429.00	42791429.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-2711428.88	-10881428.84
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	156867158.50	205445616.06
39206	Хуримтлагдсан элэгдэл	-136518780.61	-141835211.46
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17645558.85	19025558.85
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11921098.31	-13174707.96
39214	Бусад үндсэн хөрөнгө	7289885.57	7289885.57
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1743619.62	-2093539.98
393	Биет бус хөрөнгө	7420000.00	7420000.00
39301	Программ хангамж	650000.00	650000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-650000.00	-650000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	7420000.00	7420000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>566846135.01</u>	<u>592586108.91</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>566846135.01</u>	<u>592586108.91</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	566846135.01	592586108.91
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	226216378.00	226216378.00
51101	Өмч: - төрийн	226216378.00	226216378.00
512	Хуримтлагдсан үр дүн	12376901.56	38116875.46
51210	Өмнөх үеийн үр дүн	-16480513.17	12376901.56
51220	Тайлант үеийн үр дүн	28857414.73	25739973.90
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	328252855.45	328252855.45
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>566846135.01</u>	<u>592586108.91</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	578342534.42	754681554.56
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	90248746.42	50785928.56
120	Нийтлэг татварын бус орлого	90248746.42	50785928.56
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	90248746.42	50785928.56
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	300000.00	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	89948746.42	50785928.56
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	488093788.00	703895626.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	466801700.00	510337000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	466801700.00	0.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	0.00	510337000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	134976200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	134976200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	55557400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0.00	55557400.00
1330	Төсвийн захирагчдаас	3192400.00	0.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3192400.00	0.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	18099688.00	3025026.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	18099688.00	3025026.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	535961586.00	746593080.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	535961586.00	746593080.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	535387462.00	706620587.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	336984423.00	400512423.00
210101	Үндсэн цалин	335903423.00	394562423.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1081000.00	0.00
210104	Урамшуулал	0.00	5950000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44671254.00	51929896.96
210201	Тэтгэврийн даатгал	31809154.00	36315496.96
210202	Тэтгэмжийн даатгал	3215500.00	3903600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2572400.00	3122792.00
210204	Ажилгүйдлийн даатгал	643100.00	780808.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6431100.00	7807200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11964013.27	53930606.50
210301	Гэрэл, цахилгаан	1896149.27	2066161.50
210302	Түлш, халаалт	9877864.00	51708445.00
210303	Цэвэр, бохир ус	190000.00	156000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	42077003.12	28803191.00
210401	Бичиг хэрэг	6481580.00	3121600.00
210402	Тээвэр, шатахуун	32175454.00	21367741.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	619700.00	546800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	176000.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2624269.12	3767050.00
2105	Нормативд зардал	42593552.30	81462096.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	32916510.30	66035989.10
210502	Хоол, хүнс	9677042.00	10000848.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	5425259.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	135500.00	865800.00

Завханмандал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	640000.00
210604	Урсгал засвар	135500.00	225800.00
2107	Томилолт, зочны зардал	2552000.00	1660000.00
210702	Дотоод албан томилолт	2552000.00	1660000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2022544.00	1944654.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	700000.00	564000.00
210803	Даатгалын үйлчилгээ	200000.00	199250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	79000.00	48300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	25000.00	25000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	778700.00	502000.00
210807	Газрын төлбөр	50000.00	50000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	50000.00	604.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	139844.00	555500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	52387172.31	85511919.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6691792.75	39215551.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	45695379.56	46296368.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	574124.00	39972493.50
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	14124.00	0.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	14124.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	560000.00	39640000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	560000.00	39640000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	332493.50
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	332493.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	42380948.42	8088473.90
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	13523533.69	0.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-13523533.69	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	28857414.73	8088473.90

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	226,216,378.00	328,252,855.45	-16,480,513.17	537,988,720.28
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	226,216,378.00	328,252,855.45	-16,480,513.17	537,988,720.28
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	28,857,414.73	28,857,414.73
C08	2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	226,216,378.00	328,252,855.45	12,376,901.56	566,846,135.01
D01	2021 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	226,216,378.00	328,252,855.45	12,376,901.56	566,846,135.01
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	226,216,378.00	328,252,855.45	12,376,901.56	566,846,135.01
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	226,216,378.00	328,252,855.45	12,376,901.56	566,846,135.01
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	25,739,973.90	25,739,973.90
D09	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	226,216,378.00	328,252,855.45	38,116,875.46	592,586,108.91

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>488393788.00</u>	<u>703895626.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	300000.00	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	300000.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	300000.00	0.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	300000.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	488093788.00	703895626.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	466801700.00	510337000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	466801700.00	0.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	0.00	510337000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	134976200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	134976200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	55557400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0.00	55557400.00
1330	Төсвийн захирагчдаас	3192400.00	0.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3192400.00	0.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	18099688.00	3025026.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	18099688.00	3025026.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>485163788.00</u>	<u>665893026.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	485163788.00	665893026.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	484589664.00	625920532.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	336984423.00	399320600.00
210101	Үндсэн цалин	218675800.00	224756196.00
210102	Нэмэгдэл	79039323.00	120213147.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6468000.00	7262300.00
210104	Урамшуулал	32801300.00	47088957.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45026102.00	53361800.00
210201	Тэтгэврийн даатгал	32164002.00	37747400.00
210202	Тэтгэмжийн даатгал	3215500.00	3903600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2572400.00	3122900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	643100.00	780700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6431100.00	7807200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20424013.27	52330606.50
210301	Гэрэл, цахилгаан	1896149.27	2066161.50
210302	Түлш, халаалт	18337864.00	50108445.00
210303	Цэвэр, бохир ус	190000.00	156000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22894450.00	27637331.00
210401	Бичиг хэрэг	1200000.00	2874000.00
210402	Тээвэр, шатахуун	17873350.00	21328991.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	621000.00	546800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1200000.00	1472000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2000100.00	1415540.00
2105	Нормативд зардал	42810285.73	66539647.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	30466805.73	53359227.00
210502	Хоол, хүнс	9843480.00	12105420.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2500000.00	1075000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4697560.00	3105300.00

Завханмандал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл	731630.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	640000.00
210604	Урсгал засвар	3965930.00	2465300.00
2107	Томилолт, зочны зардал	2552000.00	1660000.00
210702	Дотоод албан томилолт	2552000.00	1660000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2981244.00	1944654.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	700000.00	564000.00
210803	Даатгалын үйлчилгээ	200000.00	199250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	79000.00	48300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	25000.00	25000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	878700.00	502000.00
210807	Газрын төлбөр	50000.00	50000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	50000.00	604.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	998544.00	555500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6219586.00	20020594.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6219586.00	20020594.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	574124.00	39972493.50
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	14124.00	0.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	14124.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	560000.00	39640000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	560000.00	39640000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	332493.50
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	332493.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>3230000.00</u>	<u>38002600.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>3230000.00</u>	<u>37740000.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>3230000.00</u>	<u>37740000.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	3230000.00	37740000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3230000.00	37740000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-3230000.00</u>	<u>-37740000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	262600.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	262600.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ЭЗА	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	592065400.00	568324412.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	592065400.00	568324412.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	591225400.00	567484412.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	390361700.00	390331700.00
210101	Үндсэн цалин	230773900.00	224756196.00
210102	Нэмэгдэл	116057800.00	116579247.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7262300.00	7262300.00
210104	Урамшуулал	36267700.00	41733957.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52698800.00	52698800.00
210201	Тэтгэврийн даатгал	37084400.00	37084400.00
210202	Тэтгэмжийн даатгал	3903600.00	3903600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3122900.00	3122900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	780700.00	780700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7807200.00	7807200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52662400.00	52330606.50
210301	Гэрэл, цахилгаан	1962500.00	2066161.50
210302	Түлш, халаалт	50265600.00	50108445.00
210303	Цэвэр, бохир ус	434300.00	156000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25702700.00	23137331.00
210401	Бичиг хэрэг	2984800.00	2874000.00
210402	Тээвэр, шатахуун	18836900.00	16828991.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	621000.00	546800.00
210404	Ном, хэвлэл	60000.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1200000.00	1472000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2000000.00	1415540.00
2105	Нормативд зардал	53061900.00	40256047.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	40499900.00	32343027.00
210502	Хоол, хүнс	10062000.00	6838020.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2500000.00	1075000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5045000.00	3534300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1500000.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	650000.00	640000.00
210604	Урсгал засвар	2895000.00	2894300.00
2107	Томилолт, зочны зардал	1400000.00	835000.00
210702	Дотоод албан томилолт	1400000.00	835000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2582500.00	1944654.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	700000.00	564000.00
210803	Даатгалын үйлчилгээ	200000.00	199250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	79000.00	48300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	25000.00	25000.00

Завханмандал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	878500.00	502000.00
210807	Газрын төлбөр	50000.00	50000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	50000.00	604.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	600000.00	555500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7710400.00	2415974.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7710400.00	2415974.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	840000.00	840000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	840000.00	840000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	840000.00	840000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	452616700.00	565561906.50
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	452616700.00	565561906.50
122005	Орон нутгийн төсвөөс	452616700.00	565561906.50
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	262520.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	29.00	0.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	0.00
610001	Төсвийн байгууллага	1.00	0.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	28.00	26.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	22.00	20.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	134,976,120
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	134,976,120
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	96,176,120
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	8,988,900
210102	Нэмэгдэл	-	3,633,900
210104	Урамшуулал	-	5,355,000
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	663,000
210201	Тэтгэврийн даатгал	-	663,000
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	4,500,000
210402	Тээвэр, шатахуун	-	4,500,000
2105	Нормативд зардал	0.00	26,283,600
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	21,016,200
210502	Хоол, хүнс	-	5,267,400
2107	Томилолт, зочны зардал	0.00	825,000
210702	Дотоод албан томилолт	-	825,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	54,915,620
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	54,915,620
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	38,800,000
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	38,800,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	38,800,000
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	134,976,200
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	134,976,200
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	134,976,200

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Завханмандал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Оюунсүвд гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Дагвасүрэн, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа хэрэгжүүлсэн.

Завханмандал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Завханмандал сумын Эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдсөн.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завханмандал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг нийт орлогоос 703.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 10.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 буюу 7.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мян.төг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		262.6	262.6
Авлага	354.9	18,246.5	17,891.6
Бараа материал	55,798.2	59,721.9	3,923.7
Үндсэн хөрөнгө	510,693.0	514,355.1	3,662.1
Нийт хөрөнгө	566,846.1	592,586.1	25,740.0
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	566,846.1	592,586.1	25,740.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	566,846.1	592,586.1	25,740.0

Бараа материалын дансны үлдэгдэл 3,923.7 мянган төгрөгөөр өссөн нь түүхий эд материал 1,075.9 мянган төгрөгөөр буурсан, хангамжийн материал 4,999.6 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,662.1 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар 12,218.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил олгосон, төсвийн хөрөнгөөр 37,740.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авсан, мөн элэгдлийн зардал хасагдсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 25,740.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 592,065.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 592,065.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 510,337.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 71,937.2 мянган төгрөгийн, нийт 464,380.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 55,557.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны байгууллагаас 134,976.2 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлогыг бүрдүүлсэн байна.

Нэмэлт орлогоос 58,436.2 мянган төгрөгийг урсгал зардалд, 38,800.0 мянган төгрөгийг нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд, 37,740.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

3.8 Аудитын гол асуудал

37,124.0 мянган төгрөгийн үнэ төлбөргүй шилжиж ирсэн эм, хамгаалах хэрэгслийн, 63,679.3 мянган төгрөгийн худалдаж авсан эм, хамгаалах хэрэгслийн зарцуулалтын баримтыг нэгтгэж боловсруулаагүй, зарцуулалтын бодит байдлыг шалгахад хангалттай нотлох баримт олж аваагүй, 4,499.5 мянган төгрөгийн зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан, 43,466.5 мянган төгрөгийн худалдан авалтын и-баримтыг бүрдүүлээгүй, ковидын зардлаас 1,300.0 мянган төгрөгөөр ажилчдад биеийн тамирын хувцас бэлтгэсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 145 мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулж, хугацаа хоцорсон мэдээлэл 4 байна. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл хэсэгт 29,500.0 мянган төгрөгийн худалдан авалтыг, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ хэсэгт 251,213.2 мянган төгрөгийн орлого, 159,870.8 мянган төгрөгийн зарлагыг, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр хэсэгт 18,246.5 мянган төгрөгийн авлагыг мэдээлээгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн “шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.4, 6.4.5, 6.4.8 дахь заалттай нийцэхгүй байна” гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчилд 2 заалт бүхий зөвлөмж өгч, 1.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоогдож, зөвлөмжийг хэрэгжүүлэн, төлбөрийн актыг хугацаандаа барагдуулсан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Бараа материалын зарцуулалтын баримт, үндсэн хөрөнгө, бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлд анхаарах шаардлагатай байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 186,971.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 20,282.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 148,769.4 мянган төгрөгийн болон нягтлан бодох бүртгэлээр тавих дотоод хяналт хангалтгүй алдаа зөрчилд 4 заалт бүхий зөвлөмж, 17,920.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд төлбөрийн акт тогтоосон. Шилэн данстай холбоотой 458,830.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн.

4.1 Залруулсан алдаа

Тайлант онд үүссэн 17,651.5 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй, 1,249.6 мянган төгрөгийн бараа материалыг зөв ангилж бүртгээгүй болон үр дүнгийн тайланд 1,380.9 мянган төгрөгийн, нийт 20,282.0 мянган төгрөгийн алдаанд залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт

Ковидын зардлаас 1,300,000 төгрөгөөр албан хаагчдад биеийн тамирын хувцас худалдан авч олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчиж байна.

4.3 Албан шаардлага хүргүүлээгүй

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

- ✓ 4,499.5 мянган төгрөгийн зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай нийцэхгүй, ангилал, үнэлгээ ба хуваарилалт зэрэг батламж мэдээдлүүдийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

- ✓ Батлагдсан төсвийг зарцуулахдаа Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг баримтлан ажиллаж, эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулахгүй байх;

2. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

- ✓ 43,466.6 мянган төгрөгийн худалдан авалтын и-баримтыг бүрдүүлээгүй нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтуудтай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдээдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"; Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ"; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ" гэсэн заалтуудыг мөрдөж ажиллах;

3. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

- ✓ 37,124.0 мянган төгрөгийн үнэ төлбөргүй шилжиж ирсэн эм, хамгаалах хэрэгслийн, 63.679.3 мянган төгрөгийн худалдаж авсан эм, хамгаалах хэрэгслийн зарцуулалтын баримтыг нэгтгэж боловсруулаагүй, зарцуулалтын бодит байдлыг шалгахад хангалттай нотлох баримт олж авах боломжгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7 дахь заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, толилуулга, үнэлгээ хуваарилалт зэрэг батламж мэдээдлүүдийг хангахгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

- ✓ Эмийн зарцуулалтын тооцоог тухай бүр хийж, баримтжуулалт, тайлагналтыг сайжруулах;

4. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт:

- ✓ Дотоод хяналтын нэгж байгуулаагүй, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6 дахь заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдээдлийг хангахгүй байна.

4.2 Өгсөн зөвлөмж:

- ✓ Нягтлан бодох бүртгэлээр тавих дотоод хяналтыг сайжруулах;

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

5.1 Илрүүлэлт:

- ✓ Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл хэсэгт 29,500.0 мянган төгрөгийн худалдан авалтыг, Цалингийн зардлаас бусад таван сая

төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ хэсэгт 251,213.2 мянган төгрөгийн орлого, 159,870.8 мянган төгрөгийн зарлагыг, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр хэсэгт 18,246.5 мянган төгрөгийн авлагыг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3. "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 3.2.9. таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээг гэрээ, хэлцэл, санхүүжилт өгснөөс хойш 7 хоногийн дотор энэ журмын 8 дугаар хавсралтад заасан маягтын дагуу цахимаар, 3.2.10. "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хуулбарын хамт тухайн гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор энэ журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар", 3.2.11. "зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулсан гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг гарсан өдрөөс хойш 7 хоногийн дотор энэ журмын 10 дугаар хавсралтад заасан маягтын дагуу PDF форматаар" гэсэн заалтуудтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдээдлийг хангахгүй байна.

5.2 Өгсөн зөвлөмж:

- ✓ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4 дэх хэсэгт 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтыг, 6.4.5 дахь хэсэгт санхүүжилт болон эм, хоол, шатахуун, тэтгэмжийн зардал зэрэг 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй ажил гүйлгээг, 6.4.8 дахь хэсэгт төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг тухай бүр мэдээлж хэвших;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Завханмандал сумын Эрүүл мэндийн төв	9	187.0	3	20.3	2	17.9			4	148.8
Дүн		9	187.0	3	20.3	2	17.9			4	148.8
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
2	Завханмандал сумын Эрүүл мэндийн төв	1	458.8							1	458.8
Дүн		1	458.8							1	458.8
Нийт дүн		10	645.8	3	20.3	2	17.9			5	607.6